



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 19 өдөр

Дугаар A/29

Улаанбаатар хот

**Гендэрийн салбар хорооны бүрэлдэхүүнийг  
шинэчлэн байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хүрээнд дүүргийн гендэрийн бодлого, үйл ажиллагааг тодорхойлж, салбар дундын уялдаа холбоог ханган, хамтын ажиллагааг сайжруулж, үр дүнг тооцох чиг үүрэг бүхий "Гендэрийн салбар хороо"-ны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Салбар хороо (Ж.Тамир)-нд үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2025 оны A/05 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.


4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2026 оны  
...01 дүгээр сарын ...19...-ны өдрийн А/29 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт



## САЛБАР ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дэд дарга: Засаг даргын Тамгын газрын дарга
- Гишүүд: Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
- Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
- Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
- Дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга
- Дүүргийн Боловсролын хэлтсийн дарга
- Дүүргийн Статистикийн хэлтсийн дарга
- Чингэлтэй нэгдсэн эмнэлгийн захирал
- “Тэнүүн хөгжил, мэдлэгийн урсгал” нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагын тэргүүн (зөвшилцсөнөөр)
- Нарийн бичгийн дарга: Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн Залуучуудын хөгжил, жөндөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн